



Ц.Өлзий

ШУА, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

АНГЛИ ХЭЛНИЙ ШИНЭ ҮГ БҮТЭЭХ АРГУУД

Abstract: Nowadays, some essential needs becoming more imminently that studying English among Mongolian youths and professional people. Therefore, several social and economic important steps have been made in this field. Learning English becomes foremost goal as a foreign language in many schools and universities also its' program time has increased. Many teaching staffs had been trained. English dictionaries, phrase and text books, CD and TV lessons and English courses are counted as a hundreds. As a result of this, most Mongolian intellectuals can speak, write and understand English.

Next step of English language acquisition requires us to transit and deepen into relatively higher level. Clarifying, researches must explore English while studying. In this development stage, we expect that many activities were put into practice which are Mongolian-English comparative and contrastive analysis, grammar and composition features study, various fields' professional translators and interpreters such as science, politics, economics, literature, religion ... etc training and term-terminology processing. We still need to put an attention into historical development of English, its' grammatical features and vocabulary evolution. Therefore, I have chosen and translated some researchers' masterpieces into Mongolian whose are Henry Bradley, J.A.Sheard and Otto Jespersen (His work "Growth and structure of the English language" awarded the French Institute). Although these sources were published in 1960, but still have not lost their significance today. Also, we have used up to dated materials from professional sites in internet. We hope these translating-advertising work will contribute to the dual language study.

Key words: derivational and inflectional suffixes, phrases

Энэхүү өгүүлэлд англи хэлний шинэ үг бүтээх аргуудыг тоймлон авч үзэхийг оролдлоо. Үүний учир гэвэл:

- Англи хэлийг судлахад үгийн бүтэц, зохион байгуулалтыг мэдэх явдал чухал ач

холбогдолтой. Энэ талын монгол хэл дээрх өгүүлэл, орчуулга тун цөөн байж мэдэх, надад баригдсангүй.

- Манайд англи үг, нэр томъёо олноор орж ирсээр байгаа ба голдуу тэр чигээр нь авч хэрэглэж буй. Энэ нь эх хэлний ариун нандин чанар, цэвэр оршихуйд сөргөөр нөлөөлж байна. Иймд англи үг хэллэг, нэр томъёог болж өгвөл утга адил үгээр орлуулах, оновчтой орчуулахын тулд тэдгээрийн гарал, бүтэц, утгыг сайтар нягтлууштай.
- Цаашдаа англи-монгол хэлний харьцуулсан судалгаа хийвэл энэхүү орчуулга-харьцуулсан судалгаа-сурталчилгааны материал дэвсгэр болж өгөх болов уу. Англи хэлний түүх, гарал, үгсийн өвөрмөц шинжийг харуулах үүднээс энэ хэлний судалгааг хэд хэдэн цувралаар гаргах нь зохих ач холбогдолтой гэж үзсэн юм.

Үг шинээр бий болох нь санамсаргүй явц биш юм. Хэл бүр шинэ үг бүтээх өөрийн гэсэн зүй тогтолтой. Англи хэл ч мөн шинэ үг бүтээх замаар үгсийн сангаа байнга баяжуулж, сэлбэсээр иржээ. Англи хэлнээ шинээр үг бүтээх үндсэн 3 арга бий:

1. Composition-найруулан холбох. Энэ нь хэрэглээнд байгаа хоёр үгийг холбож нийлмэл үг бүтээх арга.

2. Derivation-үүсмэл үг бүтээх. Энэ нь хуучин (гэхдээ хуучраагүй) үгээс шинэ үг бүтээнэ.

3. Root-creation-үгчилбэл язгуур буюу үндэс бүтээх. Зарим нэг ойлгомжгүй, үл мэдэх дуу чимээг даган дуурайх эсвэл ямар нэг санаандгүй илрэлийг гаргах замаар бүхэл бүтэн шинэ үг зохиох арга юм.

1. Найруулан холбох арга (Composition)

Тус бүрдээ бие даасан утгатай хоёр болон түүнээс дээш үгээс бүтсэн боловч нэг л ухагдахууныг нэрлэдэг хэллэгийг нийлмэл үг гэдэг. Жишээ нь: egomania нь ego-биеэ тоох, mania-солио, хий, сэтгэцийн гажиг, нийлээд биеэ тоох буюу хэт хувиа хичээх үзэл хэмээх утга илэрхийлнэ. Зарим хэлэнд нийлмэл үг бараг

байдаггүй. Англи хэлний нийлмэл үгийн аргуудыг бичихээс өмнө үүний талаар жаахан тодруулга хийе. Англи хэлний нийлмэл үгийг хэлбэрээр гурав, агуулгаар нь хоёр ангилж болох байна. Үүнд хэлбэрээр нь:

1. Нэг үгээр бичигдсэн, жишээ нь, hot-bed-үгчилбэл халуун ор, утгачилбал мүү муухайн үүр уурхай, тамын газар, гэмт хэргийн ертөнц.
2. Хоёр эсвэл гурван үгээр тусгай бичигдсэн, hot air-үгчилбээс халуун агаар, утгачилбал утгагүй яриа, ойлгомжгүй санаа.
3. Холбох зураасаар холбогдсон, hot-blooded-халуун цустай буюу хийрхүү, хөөргөн гэсэн утга илэрхийлж буй нь монгол хүнд шууд утгаараа ч санаа нь бараг ойролцоо бууж байна.

Агуулгаар нь:

1. Энгийн утгатай. Өгүүлбэрт өгүүлбэрийн гишүүд болж хамтдаа орох боломжтой нийлмэл үг юм. Өөрөөр хэлбэл, тэмдэг нэр ба нэр үгийн "чөлөөт" холбоо. 'A hot room'-халуун өрөө, 'hot weather'-халуун цаг агаар' гэсэн нийлмэл үгс нь өгүүлбэрт 'The day was hot' (Тэр өдөр халуун байсан), 'The weather was hot' (Цаг агаар халуун байв) гэж адил утгатай бууна.
2. Өвөрмөц утгатай. Учир нь 'hot air' (үгч. 'халуун агаар') 'hot dog'-зайдас, эсвэл хиамны хавчуургатай бөөрөнхий талх, өөрөөр хэлбэл, 'зайдастай талх' 'хиамтай талх' (үгч. 'халуун нохой') гэсэн утгатай энэ мэтийн нийлмэл үг нь өгүүлбэрт өгүүлбэрийн гишүүд болж зэрэгцэн оршиж чаддаггүй. Ингэж нийлмэл үгийг утгаар нь ялгаж чаддаг байх нь чухал.

Үндсэн сэдэв рүүгээ хандъя. Англи хэлний үг найруулан холбох аргууд нь өргөн цар хүрээтэй бөгөөд эртний Энэтхэг-Герман хэлээс улбаатай юм. Хамгийн давталт ихтэй нийлмэл үгийн төрөлд сүүл хэсэг нь ерөнхий утгаа илэрхийлж харин урьдах буюу утгваржсан хэсэг (prefixed element) нь ерөнхий утгаа тодруулж өгдөг нийлмэл үгс ордог байна. Жишээ нь: an apple-tree-алимын мод (үгчилбээс алим мод) гэвэл модны тухай гэхдээ нэг төрлийн модыг, garden flower-цэцэрлэгийн цэцэг, flower garden-цэцэгт цэцэрлэгийг өгүүлж байна. Харин үндсэн (original) Энэтхэг-Герман хэлнээ ийм төрлийн нийлмэл үгийн эхний хэсгийг үг, гэхдээ үгийн язгуур гэж нэрлэдэг байж. Учир нь энд тийн ялгал, тоо, хүйс, төлөв, цаг, бие гэх хэлзүйн хэв шинжүүд алга. Хэрэв эд өгүүлбэрт бие даасан хэлбэрээр орсон бол дээрх шинж илрэх байв. Энэ нь нийлмэл үгийн уламжлалт хэв шинж болж өнөөг хүрчээ. Иймд дээрх нийлмэл үгийн apple нь ганц, олон тоо ч биш, нэрлэх, заах харьяалахын тийн ялгал

ч биш юм¹. Эртний Энэтхэг-Герман хэлний тийн ялгалын системийг уламжилж авсан грек мэтийн хэлэнд энэ нь бас тодорхой илэрдэг. Грекийн oirodespotis-байшин, эзэн гэсэн нийлмэл үгээс байшингийн эзэн хэмээх нийлмэл үг үүсэх бөгөөд despotis-эзэн нь жинхэнэ үг, oiro-байшин нь зөвхөн язгуур юм. Энэ язгуурын ард тийн ялгал болон тооны нөхцөлүүд залган үгэнд хувиргаж өгүүлбэрт хэрэглэж болдог байв. Жишээ нь: oiros-нэрлэхийн тийн ялгал, ганц тоо, oiron-заахын тийн ялгал, ганц тоо, oiron-харьяалахын тийн ялгал, ганц тоо, oiro-нэрлэхийн тийн ялгал, олон тоо, oiros-заахын ийн ялгал, олон тоо гэх мэт.

Эндээс эртний англи хэлний тийн ялгалын тогтолцоо одоогийнхоос илүү боловсронгуй байсан нь харагдаж байна. Учир нь орчин цагийн англи хэлэнд нэр үг (зөвхөн зарим тийн ялгалд хувирдаг биеийн төлөөний нэрээс бусад) дангаараа тийн ялгалд хувирч чадахгүй, утгвар ба орхицийн тусламжаар утгаа илэрхийлдэг билээ. A tree-frog-мод мэлхий буюу модны мэлхий, a tree-fruit-модны жимс, post office-шуудангийн газар, stamp collectioning-маркны цугуулга гэх мэт үгсийн утгыг англи хэлтэн хэнбугай ч оюун ухааныхаа тусламжаар салангид бус хамтад нь зөв ойлгож чаддаг. Англи хэлний холбох зураасаар холбогдсон эдгээр нийлмэл үг, хэллэгийг өнгөц харахад зүгээр нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржсэн хоёр үг харагдах боловч харилцан бие биетэйгээ хамааралтай үгс бөгөөд, үүнийг монголчлохдоо эхний үгэнд харьяалахын тийн ялгалын -ын, -ийн, -н нөхцөлийг бид хийсвэр сэтгэхүйдээ автоматаар залгаж утгыг нь тайлдаг. Монгол хэлэнд иймэрхүү үгсийг голдуу дээрх нөхцөлтэйгөөр дуудаж, бичдэг бөгөөд алим мод гэхгүй, алимын мод, үхрийн нүд, хонин арц, эдийн засаг, номын сан, гэх мэт. Харин bod-guard гэсэн үгийг биеийн хамгаалагч гэлгүй бие хамгаалагч гэж оноосон нь оновчтой болжээ.

Дээрх хоёр нэр үгээс тогтсон нийлмэл үгсээс гадна өгүүлбэрийн бусад гишүүд бүхий олон нийлмэл үг англи хэлэнд бий. Жишээ нь: dark-blue, long-haired, ever-young, lion-hearted, over-come, inlay, outlive, upturn².

Орчин цагийн англи хэлнээ тийн ялгалыг бараг хэрэгсэхгүй болгосон нь үгс болон үгийн язгуурын ялгааг ойлгомжгүй болгож будлиантуулжээ.

Англи-Саксон толь бичгийг нээж үзвэл эртний англи хэлэнд нийлмэл үг нэн элбэг байсныг харж болно. Хэлийг бүтээх бүхий л үйл явцад үй олон нийлмэл үг англи хэлтэнгүүдийн амьдралд орж ирсээр байна. Эрт цагт нийтээр хэрэглэж байгаад өнөө хуучирсан олон нийлмэл үгс (тэднийг бүрдүүлж байсан дан үгс одоо ч түгээмэл) бол анхаарууштай л үзэгдэл юм.

Англи, герман хэлнээ чөлөөтэй хэрэглэж

¹ Henry Bradley, The making of English, 1964, x. 113

² Henry Bradley, The making of English, 1964, x. 114



байсан үг найруулан холбохуйн арга нь шинэ үгийн хэрэгцээг хангах хамгийн бэлэн арга хэрэгсэл боловч зарим нь бодит амьдралд нийцэмгүй, болхидуу болж байжээ. Аль ч хэлэнд нийлмэл үг бол тодорхойлолт, гэхдээ хагас дутуу тодорхойлолт. Хэрвээ тусагдахуун буюу объектыг нь мэддэг бол түүний утга агуулга нь санаанд шууд орж ирдэг, үүнд ч бид таатай ханддаг. Өөрөөр хэлбэл, нийлмэл үгийн үг тус бүрийн утгыг тэрхэн зуур мартаж чадахгүй бол энгийн ч гэлээ энэ үг нь бидний уураг тархинд түвэг учруулдаг. Тэдэнд оюун ухааны задлал хийхгүйгээр үй түмэн нийлмэл үгийг бид хэрэглэдэг. Монгол хэлний үхрийн нүд хэмээх нийлмэл үгийн шилжмэл утгын хувьд бид ийм жимс байдаг гэдгийг мэддэг бол тархи маань задлал хийлгүйгээр зөв утгыг шууд чиглүүлж өгдөг.

Англи хэлний нийлмэл үг нь авиа зүйн хувиралд байнга өртдөг. Эртний англи хэлний *gdspele* үгчилбэл 'good tidings' буюу "сайн үг" (эхний хэсгийг 'good' гэхийн оронд 'god' хэмээн буруу уншсанаас *gdspele* болсон) нь одоо *gospel* болж, *hsbonda*, *hs*-байшин *bonda*-оршин суугчаас бүрдсэн нийлмэл үг нь одоо *housebond* бус *husband*-нөхөр болж, яруу найргийн дүрслэл болох *day's eye-daisy* болжээ³. Харин хоёр хэсгээс бүтсэн гэж ер бодмооргүй *holy day-holiday*, *Christ's mass-Christmas* болж эхний үгийг хувилгаснаас дуудлага нь өөрчлөгджээ. Энэ үйл явц газрын нэрэнд мөн илэрдэг. Англи хэлний газрын цөөн нэр одоо ч гэсэн үгийн гарал зүйд боловсроогүй хүнд ойлгомжтой байгаа. Газрын нэрийг нэрлэсэн нийлмэл үгийн үг тус бүр нь өдөр тутмын ярианд нийтлэг. Эртний англи хэлний *stn* нь *stone*, *tn*-*town* болж үлдсэн хэдий ч газрын нэр *Stntn* нь одоо *Stonetown* бус *Stanton* болж, *Pedride* гол дээрх тосгон *Pedridan-tn* нь голын нэрийг *Parret* гэж дуудах болсноос *Petherton*-д хувирчээ.

Эндээс үзэхэд, нийлмэл үг нь тохирохуйц хэллэг болохоос өмнө гаралзүйн утга нь мартагддаг бэрхшээл бий нь илт бөгөөд энэ нь англи хэлэнд илүүтэй ажиглагддаг. Хэлний цаг мөч бүрд олон шинэ үг хэлбэрждэг боловч тэдний ихэнх нь богино настай, эсвэл маш хязгаартай хэрэглэгддэг байна. Эдгээр нь өөр үгэнд шахагдан гарах нь түгээмэл. Дундад зууны англи хэлнээ үгийг найруулан холбох аргыг маш бага буюу бараг хэрэглэхээ больсон шалтгаан гэвээс, хоёр язгуур тансаг хэл болох латин, франц хэлнээс үг зээлдэх болсонтой холбоотой. Эдгээр хэлнээс үг зээлдэх нь эх хэлний нийлмэл үг бүтээхэд орлох үг хайснаас амархан байв. Эртний англи хэлний урлаг, шинжлэх ухааны холбогдолтой үгс: *lcecraft* (*leechcraft*) анагаах ухаанд, *scopesrft* яруу найрагт, *tungolcrft* одон оронд, *rimcrft* арифметикт хэрэглэж байсан үгс хэлнээс аль хэдийнээ алга болж байрыг нь латин

хэлнээс францаар дамжин эсвэл грекээс франц, латин хэлээр дамжин орж ирсэн зээлдвэр үгс зээлжээ. XIV зуунд нэгэн лам *ayenbite* (*inwyt*)-гэмшил хэмээх үгийг анх бичиж өөрийн шинэ үгийг бусад зохиолчид хэрэглээсэй гэж хүссэн боловч амжилт олоогүй юм. Магадгүй Латин, Франц хэлний үүнтэй адил утгатай үг англичуудад илүү таалагдсан байх. Сүүлийн үед энгийн буюу хуулбар үг сайн боловсруулсан нийлмэл үгийг орлож байна. Жишээ нь англичууд *steamboat*, *steamship*-ээс илүү *steamer* (эд бүгд "уурын усан онгоц" хэмээх адил утгатай)-ийг хэрэглэж байна. Орчин цагийн англи хэлэнд нийлмэл үг нэг их олонгүй ч шинээр тасралтгүй бий болсоор байна. Хэн ч хэзээ ч хэрэглэж байгаагүй, хэрэглэх ч үгүй байж болох *purple-eared* үгийг шаардлага гарвал энэ үг англи-бус хэллэг гэж хэн ч хэлэхгүй. Хэлний зөнгөөр ямар нийлмэл үгийг шууд хүлээн авч, ямыг нь авахгүй байгааг тодорхой хэлэхэд хэцүү. Ерөнхийдөө их хэрэглэгддэг энгийн үгсээс бүрдсэн шинэ нийлмэл үг хэрэглээнд шууд ордог нь батлагдсан. Нэг тийм хэв шинж бол 'parasynthetic' буюу үгэнд дагавар залгаж бүтээсэн *blue-eyed*, *long-haired* зэрэг бүтэцтэй үгс юм. Хуучирч буй англи хэллэг үг *blue-eyed* мэтээс *with blue eyed* мэтийн шинэ нийлмэл үгийг чөлөөтэй бүтээж байна.

Орчин цагийн англи хэлний найруулан холбохуйн нэг өвөрмөц төрөл бол хэлц үйл үг юм. Жишээ нь, *get up*, *turn about*, *take down*. Герман хэл мэддэг хүн үүнийг ерөнхийд нь гадарладаг. Герман толь бичгүүдэд *aufgeben* буюу *auf* 'up' үйл хавсрал ба *geben* 'to give' үйл үгээс бүтсэн нийлмэл үг бий. Эс тухайлах хэлбэрээр үүнийг нэг үгээр бичдэг ба үйлшсэн хавсралт хэсэг нь эхэнд нь ордог. 'I give it up'-ийг Германаар *ich gebe es auf* гэх ба энд хоёр хэсэг нь бие даасан үгээр орж тусагдахуун төлөөний нэр нь үйл үг, үйл хавсралын дундуур орж иржээ. Эднийг хэлц үйл үг гэдэг бөгөөд зарим нь тусагдахуунтай, зарим нь тусагдахуунгүй байдаг. Мөн зарим нь ойлгоход хялбар байхад (*catch up with*-гүйцэж түрүүлэх) зарим нь хэвшмэл хэллэг шинжтэй учир ойлгоход хэцүү (*catch on*-ойлгох). Учир нь энэ хэллэг нь дан үйл үгийнхээ үндсэн болон ойролцоо утгуудаас ондоо байдаг. Урьд нь иймэрхүү холбоог нийлмэл үг гэхээс илүү хэлц үйл үг гээд, үйл үг, үйл хавсрал хоёр нь жинхэнэ бие даасан, тусгай тусгай үгс юм гэж үзэж байсан нь батлагдсан. Зарим тохиолдолд үйл хавсралыг үйл үгийн урьд, нөгөө талаар ард нь оруулахыг хэлц үгс шаарддаг юм. Гэхдээ орчин цагийн англи хэлний үргэлжилсэн үгийн зохиол, яриа, хүүрнэлд үйл хавсралыг дандаа сүүлд нь тавих ёстой.

³ Otto Jespersen., *Growth and structure of the English language.*, Basil Blackwell Oxford., 1962. p.162

Яруу найрагт:

"Then a beam of fun outbroke

On the bearded mouth that speak"⁴ гэж Браунин бичжээ. Орчуулбаас:

"Хүүрнэн буй сахалтай уруул дээр
Хөгжилтэй сайхан инээд дэгдэв"

Гэхдээ outbroke-ийг зөвхөн яруу найрагт хэрэглэх бөгөөд үргэлжилсэн үгийн зохиол, хүүрнэл, яриа зэрэгт 'broke out' гэх нь оновчтой юм.

Энэ аргаар утгын нарийн ширийнийг илэрхийлэхдээ англи хэл нь грек, латин хэлний нийлмэл үгүүдтэй өрсөлддөг бөгөөд нийлмэл үйл үгсийг идэвхтэй хэрэглэдгээрээ ром хэлний нийлмэл үгүүдээс (латин хэлэнд суурилж хөгжсөн итали, франц, испани хэл) үлэмж давуу хөгжжээ.

Англи хэлэнд урдаа үйл хавсрал бүхий нэлээд олон үйл үгс байна. Жишээ нь: overtake, upset, understand, outstay гэх мэт. Гэвч ихэнхдээ тэдний утга нь үйл үг+үйл хавсрал хэлбэртэй нийлмэл үгийн утгаас өөр байдаг нь сонин. Жишээ нь: 'to overtake a person'-ийн утга нь 'to take a person over'-тэй төсгүй, 'to upset a thing' (нураах) нь 'to set a thing up' (босгох)-аас яг эсрэг утгатай байгааг харж болно. Ийм төрлийн нийлмэл үг хэлэнд нэлээд эрт цагт үүссэн бөгөөд найруулан холбох зарчмууд нь бараг устсан. Иймээс үүнтэй адил хэв шинжтэй шинэ үгс бүтээх боломж бараг үгүй болжээ. Орчин цагийн хэлний нийтлэг хандлага ч ийм загвартай шинэ үг бүтээхийг эсэргүүцэж байгаа бөгөөд XVI зуунаас хойш цөөхөн үг өдий хүрсэн юм. Үйл хавсралын араас үйл язгуур, үйлшсэн нэр үг, үйлт нэр залгаж бүтээсэн нийлмэл үгс болох outfit, outbreak, income, down-fall, down-sitting, uprising, onlooker, outfit, forthcoming зэрэг нийлмэл үг нь XVI зуунаас өмнө амархан бүрэлдэн тогтож байсан бөгөөд үнэхээр элбэг, биширмээр яруу утга учиртай байв. To fit out-аас to fit up хэмээн ярих нь олонтоо ба upfit, upfitter гэх нь чамин санагддаг. Үнэхээр эрт цагт дэлгэрч байсан тэдгээр үгс одоо нийтлэг хэрэглээнээс арилжээ. Библийн орчуулагчид "My down-sitting and mine uprising" гэж байсан бол орчин цагийн англи хэлний адил хэллэг нь "My sitting down and my rising up" байх нь.

Яруу найргийн ном зохиолууд дахь үг найруулах зарчмууд нь ердийн үргэлжилсэн үгийн зохиолуудаасаа нэлээн ялгардаг. Шүлэг, яруу найрагт чөлөөтэй хэрэглэж байсан олон нийлмэл үгс энгийн хэрэглээнд бол дэндүү амьдралгүй, дэндүү утгагүй, дэндүү улиг санагдах хэдий ч нөгөө талаас үзвэл үргэлжилсэн үгийн зохиолд үл нийцэх шинэ, шинэ нийлмэл үгсийг бүтээхдээ задгай сэтгэх агуу эрх чөлөө английн шүлэг, яруу найрагт байна гэж үзэж болохоор. Шекспир "proud-pied April", "a heaven-kissing hill", "the world-without-end hour" зэрэг олон яруу

⁴ Henry Bradley 'The making of english', New York., 1964. p.122

тунгалаг, тансаг сайхан утгатай нийлмэл үгсийг анх хэрэглэж байсан бол Спэнсэр (Английн яруу найрагч) ч түүнээс дутахгүй яруу гэхдээ арай цөөхөн "self-consuming care", "silver-dropping tears" (үгч. мөнгөн дусалт нулимс) зэрэг нийлмэл үгийг анх бүтээж хэрэглэжээ. Спэнсэрийн зохиолд гардаг "Rosy-fingered Morn" (үүрийн улаан гэгээ) хэмээх нийлмэл үг нь Хомэр (МЭӨ IX-VIII зуунд амьдарч байсан Грекийн туульсын зохиолч)-ийн rhododaktulos s үгийн үгчилсэн орчуулга юм. Спэнсэр орчин үеийн шүлэг, яруу найрагт хуучин үг хэллэгийг гарамгай ашиглагдаараа танигдсан хүн⁵. Ер нь Чэпмэнээс эхлэн Хомэрийн зохиолуудыг орчуулагчид, нийлмэл зүйрлэсэн үгсийг грек хэлнээс хуулан орчуулж байсан бөгөөд энэ л сувгаар английн сонгодог яруу найргуудын үг хэллэгийг баяжуулж авчээ⁶. Үүнээс гадна английн олон зохиолч, орчуулагчид эх хэлнийхээ үгсийн санг баяжуулж байсан нь гарцаагүй. Интернет ашиглагч хэн бүхний мэдэх "yahoo" хэмээх үгийг анх английн шог зохиолч Свифт "Гулливерийн аялал" гэдэг номондоо анх бичсэн байдаг. Тэд өөрсдийн үзэл бодол, дуу хоолойгоо хэрхэн өөр өөрийнхөөрөө илэрхийлж, үгсийн сангаа баяжуулах эдгээр аргыг хэрхэн хэрэглэж зохиол бүтээлдээ тусгаж байсныг судалбаас сонирхолтой бөгөөд энэ асуудал хэл судлаачаас илүү утга зохиол шүүмжээч, судлаачдад хамаарах юм.

2. Үүсмэл үг бүтээхүй

Энд бид үгийн үндсэнд угтвар, дагавар залган шинэ үг бүтээх (unwisely нь wise язгуураас үүсэжээ) англи хэлний аргуудыг дурдана. Эртний англи хэлний үгсийн сангийн ихээхэн хэсгийг ийм маягаар үүссэн үгс эзэлдэг. Тэдгээр үүсмэл үгсийн ихэнх нь англичууд эх газраас аралд шилжиж ирэхээс өмнө бүрэлдэн тогтсон бөгөөд бүрдүүлэгч үйл явц нь нэн эртний англи хэлний уран зохиолын үеэс ч өмнө хуучраад байсан байна. Энэ мэдэгдлийг тодруулах жаахан тайлбар хийе. Laughter нь laugh гэдгээс гаралтай гэдгийг бүгд мэддэг хэрнээ энэ процессоор шинэ нэр үг бүтээх тухай одоо хэн ч саналтгүй болжээ. Эртний англи хэл бие даасан хэл болохоос ч өмнө -ter дагавар алга болсон байна. Энэ хэлнээ оршиж байсан бусад олон дагаврыг ийм л маягаар шинэ үг бүтээхэд хэрэглэхээ больжээ. Эртний англи хэлэнд нэр үг, тэмдэг нэр, үйл үгээс эгшиг хувиргалтаар бий болсон үүсмэл үйл үгсийн томоохон төрөл байдаг ба жишээ нь: talu буюу tale (өгүүлэл) хэмээх нэр үгээс tel-lan буюу to tell (өгүүлэх) хэмээх үйл үг үүсэжээ. Ийм маягаар, tun-tynan, blod (blood-цус)-bledan (to bleed-цус алдах), blac (white, pale,-цагаан, хувхай)-аас blacan (to bleach-цайрах, хувхайрах, гандах) үүсжээ. Эдгээр үгийг бусад герман овгийн

⁵ Otto Jespersen., Growth and structure of the English language., Basil Blackwell Oxford., 1962. p.216

⁶ Henry Bradley, The making of English, 1964, x.126



хэлүүдийн ижил хэллэгтэй харьцуулж үзвэл –jo (ё гэж дуудагддаг) гэх төлөв, цаг, биеийг заадаг дагавраас гаралтай нь тогтоогдсон. Уг дагаврыг нэр үг, тэмдэг нэр, үйл үгийн язгуур дээр залгаж шинэ үйл үгийн язгуур үүсгэдэг байв. Англи хэлэнд энэ нь –jan (-ян) хэлбэртэй тогтож улмаар –an болсон нь үзэгдэнэ. Дээр дурдсан үйл үгсийн арай эртний хэлбэр бол taljan, saljan, tunjan, blodjan, blaikjan байжээ. Эд бүгдээрээ эртний англи хэл нь бичгийн хэл болохоос өмнө бүрэлдэн тогтсон ба бичгийн хэл үүссэн тэр цагт өмнө нь шинэ үйл үгийг бүтээж байсан дээрх процесс алга болсон байв. Тухайн үед бүх үйл үгс эртний англи хэлэнд нэн эртнээс өвлөгдсөн эгшиг хувиргалтаар хэлбэржин тогтсон байх магадтай. To make good буюу gdan хэмээх үйл үг нь cl буюу cool, clan буюу to cool-ийн хоорондох харьцаа лугаа ижил gdoos үүссэн байх магадтай бөгөөд ийм тохиол дахиж давтагдаагүй юм. Эртний англи хэл, бидэнд мэдэгдсэн нэн эрт цагт үг бүтээж байсан хамгийн чухал аргуудынхаа нэгийг гээчихжээ.

Эртний англи хэлэнд өргөн дэлгэр хэрэглэгдэж байсан үүсмэл үгсийн шинэ загварууд өнөө үед ч байна. Хамгийн чухал гэсэн хэдийг энд өгүүлье. Нэр үгийн язгуур дээр үйл үгийг хувиргах дагаврууд залгах замаар нэрээс үйл үг үүссэн: wilcumian-to welcome-урих гэсэн үйл үг нь wilcuma-a welcome guest-зочин урихуй хэмээх нэр үгээс гаралтай. (ic wilcumige-I welcome-Би урьж байна, ic wilcumode-I welcomed Би урьсан) Хожим нь үгийн эцсийн үеэ гэсэнээр үүсмэл үйл үгийн эс тухайлах хэлбэр, захиран хүсэх төлөв, олон тоо болон ганц тоот нэгдүгээр биеийн одоо цагийн хэлбэр зэрэг нь анхдагч нэр үгтэйгээ ижил хэлбэртэй болжээ. Тэгээд шинэ үг бүтээх шаардлагагүй мэт болж нэр үгийг мөн үйл үгээр хэрэглэх болсон байна. Тэр цагаас хойш энэ арга нь орчин үед уламжлагдан ирсэн юм. Орчин цагийн англи хэлний love-loves (хайр-хайрлах), sleep-sleeps (нойр-нойрсох) зэрэг нэрээс үйл үг үүсгэсэн олон үг чухам XV зууны англи хэлний өөрийн зүй тогтлоор хөгжсөн хэлбэрүүдийн үргэлжлэл юм⁷. Ярианы хэлнээ англичууд гайхалтай чөлөөтэйгөөр зөвхөн нэр үгээс ч бус бас хэлц хэллэгээс шинэ үйл үг үүсгэдэг болж. "He 'my-dear-fellow'-ed me all the day" нь зөвшөөрөхүйц англи яриа юм. Нөгөө талаар орчин цагийн англи хэлэнд бараг үйл үг боловч үзэгдлийг илэрхийлэхдээ бие даан нэр үгээр ордог маш олон үг байна. 'a wash', 'a shave', 'a dig in the ribs' гэх мэт. Хааяа нэр үг нь үйл үгийг үүсгэж, тэр нь эргээд өөр нэр үгийг бий болгодог ба энэ гурвын дуудлага, бичлэг яг адил. 'The smoke of a pipe', 'to smoke a pipe', 'to have a smoke' гэх мэт. Мөн эртний англи хэлээс уламжлагдсан дагавруудын аргаар шинэ, шинэ үүсмэл үг үүссээр байгаа нь cleverness, cleverly, gentlemanly, rogu-

⁷ Otto Jespersen., Growth and structure of the English language., Basil Blackwell Oxford., 1962. p.153

ish, thinker, noisy, horsemanship–ээс (эдгээр нь эртний англи хэлэнд арай өөр хэлбэртэй байсан нь мэдээж) харагдаж байна. Un- угтварыг үйл үгийн өмнө залгаснаар эсрэг үйл гарч ирнэ Fasten-бөхлөх, unfasten-суллах, cover-бүтээх, uncover-дэлгэх гэх мэт. Харин be-угтвартай үйл үгийн жагсаалт мөд дуусахгүй шинжтэй: become, befog, befriend, beloved....

Түүнээс гадна эртний англи хэлний –isc (одоо -ish)-ийг байр, хүний нэрэнд залгаж тэмдэг нэр үүсгэхэд голчлон хэрэглэж байв. Englisc (English), Lundenisc (Londonish). Үүнийг мөн нэр үгэнд залгаж онцлог чанар заах тэмдэг нэр үүсгэсэн цөөн жишээ бий. Folcisc (popular), cildisc (childish). Ойролцоогоор 1400 оны үед үүнийг өнгө заасан нэрэнд залгаж тухайн өнгөний бага хэмжээг илэрхийлсэн тэмдэг нэр анх үүсжээ. Bluish-хөхөвтөр, blackish-харавтар. Хожим энэ дагавар нэлээн түгээмэл болж 'somewhat good' 'somewhat bad' (зарим талаараа сайн, зарим талаараа муу) гэж ярихын оронд goodish, baddish гэж дан үгээр илэрхийлэх болсон байна.

Эртний англи хэлний тэмдэг нэрээс шинж байдлын үйл хавсрал үүсгэх -lice буюу -ly төгсгөл нь дундад зууны англи хэлэнд түгээмэл болсны учир нь эцсийн –e-г дуудахаа больж тэмдэг нэр болон түүнтэй холбоотой үйл хавсрал хоёр адил хэлбэртэй болсноос үүджээ.

XVI зууны эхээр дэс тоо илэрхийлэх үйл хавсралын хэрэг гарчээ. Өөрөөр хэлбэл "in the first, second, or third place" гэсэн утга заах энгийн буюу дан үг (single word) шаардагдсан байна. Ингээд тооны нэрэнд үйл хавсралын –ly төгсгөл залгаж үг хэрэгцээг хангасан бөгөөд эртний англи хэлэнд огт байдаггүй firstly, secondly, thirdly, fourthly зэрэг дэс тоот үйл хавсралууд үүссэн түүхтэй.

Эртний англи хэлнээс хойш тухайн хэлэнд оршин байсан дагавар, угтвар бүхий маш олон тооны шинэ, шинэ үүсмэл үгс нь англи хэлний үгсийн санг баяжуулж ирсэн ба энэ аргаар шинэ үгс бүтээх явц хойшид ч үргэлжлэх нь гарцаагүй. Хэдийгээр үүсмэл үг бүтээх үндэсний механизмаас хэсэгхэн нь хуучирсан ч энэ нь тэр бүр хэлний хэрэгцээ шаардлагыг хангаж чаддаггүй ба энэ тохиолдолд бусад хэлний үгсийг өргөн хэрэглэсээр иржээ. Франц, латин хэлний дагавар бүхий эртний үүсмэл үгс нь англи хэлнээ цөөнгүй. Англи хэлний үгсийн санд орж ирсэн derive-derivation, esteem-estimation, condemn-comdemnation гэх мэт үгсийн –ation дагаварыг үйл үгээс гадна үйлийн ажиллагааг илтгэдэг нэр үгсийг бүтээх нийцтэй арга хэмээн англиар яригчид үздэг ажгуу. Энэ нийтлэг, танил дагавар маань хэлний жинхэнэ хэрэгцээг хангаж өгчээ. Яагаад гэвэл үйл ажиллагааны нэр үгс бүрдүүлэгч англи хэлний цорын ганц арга–ing дагаврын арга нь бүрэн нийцсэн, төгс утгыг гаргаж чаддаггүй

байв. Өөр нэгэн харь хэлний дагавар –ative нь латин хэлний үүсмэл үгсэд нийтлэг тохиолддог ч англи хэлэнд олонгүй (заримыг дурдвал: talkative-чалчаа, яриасаг, walkative, authoritative, imaginative).

Заримдаа харь хэлний дагавруудыг өөрийн болгох гэсэн оролдлогууд бүтэлгүйтэж байсан нь зайлшгүй хэрэгцээ байгаагүйтэй холбоотой болов уу. Жишээ нь: Виклифийн (английн шашны шинэчлэгч, номлогч) анх хэрэглэсэн everlastingtee нь нийтэд хүрч чадаагүй бөгөөд -tee дагаврыг үгэнд залгахыг хориглосон. Яагаад гэвэл үндэсний уламжлалт дагавар -ness нь байсан тул харь хэлний ойролцоо утгатай үгийн шаардлага гарсангүй.

Франц хэлний -age, -al, -ment, -able болон грек гаралтай -ize, -ist, -ism, -ite зэрэг олон дагаврыг англи хэлний үүсмэл үгсийг бүтээхэд өргөнөөр ашигласаар иржээ.

Эртний англи хэлийг бусад Энэтхэг-Герман хэлний нийлмэл үгстэй харьцуулж үзвэл жижиг зүйлийг илэрхийлэх дагаврууд гайхалтай цөөн бөгөөд; тэднийг маш ховор хэрэглэдэг байсан байна. Тэдний нэг нь tunincel гэдгийн -in-cel байсан ба тосгон эсвэл жижиг эдлэн газар гэсэн утгатай. Гэвч энэ нь дундад зууны англи хэлэнд уламжлагдсангүй. Эртний норс хэлнээс (Norse-Викингийн булаан эзлэгчдийн хэл буюу Скандинавийн Норвеги) уламжлагдан ирсэн жижиг зүйлийг өхөөрдсөн маягаар хэрэглэдэг -ling дагавар бүхий үгс (gosling г.м) байдаг. Орчин цагийн англи хэлэнд норс дагавруудыг жижиг, өхөөрдөм зүйлийг илтгэх нэр үгийг бүтээхэд түгээмэл хэрэглэж байна. Kingling, princeling, squirreling, duckling (нугасны дэгдээхэй)... Уг дагавраар жижиг, өхөөрдөм зүйлийг нэрлээд зогсохгүй, хэрэггүй зүйлийг илтгэхэд хэрэглэж байна. XIV зуунд Dutch (Герман, Австри, Шинэ Зеланд гэх мэтийг багтаасан герман хэлүүд) ба Flemish (Бельги болон хөрш Франц, Нидерланд)–ийн энэ төрлийн дагавар болох –kin (Германы –chen-тэй төстэй) англи хэлэнд орж иржээ. Энэ нь голдуу хүний багын нэрэнд хэрэглэгдэж Willekin буюу жаахан Уйльям, Jankin-бяцхан Жон болж байв. Энэ загвар маш нийтлэг болж орчин үеийн хүний нэрэнд гүнзгий үл мөрөө үлдээсэн нь Jenkins, Atkins, Dawkins, Wilkins–аас харагдаж байна. Одоо харин энэ дагаврыг ердийн нэр үгстэй хамт хэрэглэж байгаа бөгөөд шог ярианд ямар нэг нэр үгэнд жижгэрүүлэх, өхөөрдөх маягаар –kin залгаж байна. Үүнээс илүү энгийн, нийтлэг дагавар бол франц хэлээс зээлдсэн –let юм. Үүнийг cloudlet, streamlet, leaflet, ringlet, (үсний бяцхан цагираг зүүлт) booklet (жижиг ном буюу товхимол) зэрэг маш олон төрөлх англи үгэнд залгасан жишээ байна. Дундад зууны англи хэлэнд бий болсон –ie (=у)-г үгэнд залгаж жижиг зүйлийг, мөн өхөөрдөж хайрласан байдлыг илэрхийлсэн sweetie-хайрт минь, хонгор минь, birdie-дэгдээхий,

шувуухай гэх мэт үгс байна.

Англи хэлний гүнд орж ирсэн хоёроос гурван харь хэлний угтвар байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн хэрэгтэй нь латин хэлний re- юм. Энэ угтвар бүхий бүх үгсийг ямар ч толь бичиг үл багтаах ба re- бүхий нийлмэл үгс нь un-тай тэмдэг нэрс лүгээ адил тоолж барамгүй олон юм. Дундад зууны англи хэлэнд again-ийг угтварын үүргээр хэрэглэдэг байсан бөгөөд ийм маягаар бүтсэн үгс одоо хуучирчээ. Энэ угтвар нь дээр өгүүлсэн латин хэлний re-д шахагдан гарсан байна. Дараа нь латин, франц хэлний dis-хэрэглээнд орж иржээ. Лидгэт (английн яруу найрагч) 1430-аад оны үеийн зохиолдоо distrust гэдэг үгийг анх хэрэглэсэн хэдий ч 100 жил өнгөрсөн хойно англи үгсэд энэ угтварыг залгах нь нийтлэг болжээ. Энэ угтвараар эхэлсэн үй түмэн үгс XVI-XVII зуунд үүссэн ч ихэнх нь хуучирч 1700 оноос хойш тун цөөхөн шинэ үгс бий болжээ. Энэ угтвар бүхий, хэдэн зууны турш хэзээ ч хэрэглэж байгаагүй dislove мэтийн үгийг ойлгоход ямар ч англи хүнд түвэг байхгүй тийм жинхэнэ англи хэлний угтвар шиг хэрэглэгдсээр байна. Мөн франц хэлний en-, em-ээр (адилхан, гэхдээ em-ийг b,m,p үсгийн өмнө хэрэглэдэг) хэд хэдэн үүсмэл үгс бүтээгээд байна: endear, embody, embog, enlarge, enliven, emigrate. Грек хэлний anti- буюу эсрэг хэмээх угтварыг англи хэл шүүд өөрийн болгож авчээ. Anti-income-tax, anti-AIDS, anti-traditional, anti-romantic зэргийг англи хэлтэн бүр ойлгодог ба ийм үгийн тоо өссөөр байна. Энэ нь үүсмэл гэхээс илүү нийлмэл үгийн шинжтэй авч anti-нь англи хэлнээ дангаараа оршдоггүй учир угтвар гэх нь илүү нийцтэй. Энэхүү хуучин үгээс (гэхдээ хуучраагүй) шинэ үг бүтээх замаар үүсмэл үг бүтээхэд урьд нь дурдаж байгаагүй, гэвч англи хэлний үгийн санд нэлээд чухал үүрэгтэй хоёр процесс явагддаг. Эднийг back formation ба shortening гэдэг.

Back-Formation

Back-formation. Үүнийг толь бичигт “Нэг үгээс бүтсэн, эсвэл бүтсэн юм шиг байдалтай харагдах үг. Голдуу дагаврын аргаар бүтдэг, жишээ нь: The verb ‘televise’ is a back formation from television-‘televise’ үйл үг нь ‘television’ гэдгээс гаралтай” гэжээ. Энэ нэр томъёог монгол хэлнээ хэрхэн буулгахаа мэдэхгүй байна. Монгол хэлний хувьд “цэцэрлэг” хэмээх нэр үг нь цэцэг гэдэг язгуур үгээс үүдэлтэй. Үүнтэй л адил юм. Зарим нэг сайн мэдэх шинэ биш хуулбарласан дагавартай, төөрөгдүүлмээр олон үг англи хэлэнд бий. Ийм үгийн эхний хэсэг нь оршихуйгаа нууцхан илтгэдэг гэж таамагласнаас хуучнаас шинэ үг бүтээх бодлогогүй ажлыг эхлүүлнэ. Өөрийн дагавраар уу эсвэл өөр дагаврыг орлуулж бүтсэн үү гэдэг нь эргэлзээтэй байдаг. Beggar-аас уламжлан ийм замаар бүтсэн to beg хэмээх үйл үгийг эртний франц хэлний begar-буюу хар лам лугаа адил гүйлгэ гүйн гэдсээ тэжээдэг (манайхаар бадарчин юм уу даа) Beghards гэгддэг шашны бүлгийн гишүүний



нэрээс зээлдсэн гэж зарим нэрт эрдэмтэд үздэг. Энэ гарвал зүй нь маргаантай. Butcher-яргачин, нядлаач нэр үг нь үнэхээр франц хэлний boucher-аас үүсэлтэй боловч энэ үгийн төгсгөл нь англи хэлний нийтлэг дагавартай гарлын хувьд төсгүй. Гэвч англичууд to butch, 'the butchering business' хэмээн ярьж, хэрэглэсээр иржээ. Butler-ээс buttle (одоогийнхоор бол to pour out liquor-сархад сөгнөх), cutler-с cuttle буюу to make knives үүсжээ. Нэр үг pedlar-доншуур наймаачин нь үйл үг peddle, тэмдэг нэр peddling-ээс түрүүн үүссэн ба broker нь үйл үг to broke (одоо хуучирсан), үйлшсэн нэр үг broking-оос эртнийх юм. Groveling-ийн жинхэнэ гарал нь уруу царайлсан хэмээх утгатай үйл хавсрал байж. Энэ нь эртний хэллэг on grufe-с үүссэн ба (мөн ижил утгатай) бусад олон үйл хавсралуудад тохиолддог -ling дагаврыг залгаж бүрэлдсэн байна. Одоо backling, (backwards-арагшаа), headling (head-first) зэрэгтэй адил нэлээд хуучирчээ. Гэвч groveling-ийн одоо цагийн нөхцөлт үйл үг нь ойлгомжгүй байсан ба үүнээс grovel үйл үг үүсжээ. Үүнтэй төстэй sidle, darkle үйл үгс нь sideling, darkling хэмээх эрт цагийн үйл хавсралуудаас бүтжээ. Liaison хэмээх нэр үг нь liaise гэх үйл үгээ үүсгэжээ. Зуун тавь гаруй жилийн өмнө Banting нэрт залуугийн бүтээсэн Banting method хэмээх тураах аргын талаар ихээхэн яриа гарч мөн to bant хэмээх үйл үг үүсэж маш өргөн хэрэглэгдэж байсан байна. 1842 онд cycle, 1868 онд tricycle-гурван дугуйт, 1869 онд bicycle (бүгд унадаг дугуй) үгс үүссэн авч хамгийн анхны хэлбэр нь богинохон учраас нөгөө хоёрынхоо үүргээр давхар орж хэрэглэгдсээр байна⁸.

Shortening-богиносгохуй

Хөгийн, тэвдсэн, болгоомжгүй, бүдүүлэг орломол үгс олон хэлэнд нийтлэг. Жишээ нь: potatoes, tobacco-г taters, bacca гэж бүдүүлэгдүү товчлон буруу дууддаг бөгөөд үүнийг шинэ үг гэж хэлж чадахгүй. Гэвч хүн жинхэнэ үг ба түүний богиносгосон хэлбэр хоёрыг хоёуланг нь өөр өөр утгаар өргөн хэрэглэх нь олонтоо. Толь бичиг зохиогчид богиносгосон хэлбэрийг тодорхой үгээр авахаас зайлсхийдэг. Гэвч богиносгохуй нь хамгийн тодорхой утга санаа, үүсмэл үгийн нэг төрөл, англи хэлний үгийн нөөцийг нэмэгдүүлэхэд багагүй хувь нэмэртэй процесс болдог ажгуу.

Товчилсон хэлбэр нь жинхэнэ хэлбэр лүгээ адил утгыг нарийн гаргаж чадах учраас эднийг бие даасан тусгай үгс гэж авч үздэг. Гэхдээ урт хэлбэрийг арай онцгой, чухал үед хэрэглэдэг. Omnibus, bus хоёр нь утгын хувьд нэг л объектыг илэрхийлдгээрээ ижил утгатай гэвч туйлын синоним бус. Учир нь нэг нь илүү ойлгомжтой бас ондоо үед хэрэглэгддэг. Omnibus одоо нэлээн хуучирсан. Photograph-photo, bicycle-bike, fanatic-fan зэрэг товчилсон хэлбэрүүдийг хэлний зарим хүмүүс дүрмийн бус үгс гэж нэг их сайшаадаггүй.

⁸ Henry Bradley, The making of English, 1964. x.147

Заримдаа товчилсон хэлбэр нь нөгөөгөө хэрэглээнээс хөөдөг нь periwig-ийн байрыг wig (хиймэл үс) эзэлснээс тодорхой харагдаж байна.

Харин давталт ихтэй товчилсон буюу богиносгосон үг нь өөрийн утгын-хөгжлийг (sense-development) туулдаг бол жинхэнэ үг тэгдэггүй. Omnibus-с bus нь ойлгомжтой үг гэдгийг хэн нэгэн үгүйсгэж болох авч cabriolet-ийн богиносгосон дуудлага болох cab-ийг нөгөөгөөсөө илүү ойлгомжтой гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж лав чадахгүй. Cab-хөлсний тэрэг, cabriolet-морин тэрэг хоёр нь үнэндээ нэг төрлийн тээврийн хэрэгсэл бус. Мөн гэрлээгүй эмэгтэйд өгдөг Miss ба Mrs. (миссис хэмээн дуудагдана) хоёр бие биеэсээ утгаараа, mistress-ээс, мөн богиносгосон хэлбэрээрээ эрс ялгардаг. Gent-ийг хэлний хүмүүс gentleman-ий сайн мэдэх товчлол хэмээн хэрэглэж ирсэн цаг ч бий. Гэвч энэ нь язгууртнуудын амнаас санаандгүй гарсан үг байв. Энэ үг үгсийн санд үлдэж, толь бичигт оржээ. Мөн ийм байдлаар гарсан cit нь citizen, city man-ий товчлол юм.

Зүггүйтэн гаргасан зарим товчлол одоо жинхэнэ гарлынхаа утгаас өөрөөр хэрэглэгдэж байна. Extra allowance-нэмэлт тэтгэмж зэрэг хэллэг дэх extra нь латин үг биш гэхдээ extraordinary-ийн хураангуй юм. Chap бол chapman-ий багасгасан хэлбэр, зөв утга нь trader буюу худалдаачин юм гэдгийг зөвхөн гарал зүй судлаачид мэднэ.

Дундад зууны ба орчин цагийн англи хэлний эхэн үед үгийн өргөлтөт үеийн урьд нь орсон эхний эгшгийг гээх явдал цөөнгүй байв. Ийм маягаар эгшгээр эхэлсэн үг нь хоёрдогч хэлбэрийг үүсгэсэн бөгөөд энэ хоёр өөр өөр утгаар хөгжжээ. Assize, size хоёр утгаараа ялгаатай бөгөөд тэднийг нэг үгс юм гэж хэн ч үл бодох агаад нэг нь нөгөөгийнхөө богиносгосон хэлбэр юм. "To tend the sock"-ийн tend нь attend-аас гаралтай, гэхдээ энэ хоёр үйл үг нь ойрын синоним (ойролцоо утгатай үг) бус. Арай дээхэн үед all one байсан одоогийн alone нь Элизабетийн үед тэмдэг нэрийн үүргээр lone болж богиносч байв⁹. Mendamend-аас гаралтай. Энгийн амьдралд богино хэлбэрийг илүү хэрэглэх ба урт хэлбэрийг арай онцгой үед хэрэглэдэг. Жишээ нь: mending a stocking-оймс нөхөх, amending an Act of Parliament-Парламентийн хуульд засвар оруулах. Vie нь орчин цагийн envy-тэй ижил үг биш, envy-г богиносгосон хэлбэр юм. Латин хэлний invitare-маргалдах үг нь франц хэлэнд envier болж англи хэлэнд орж ирсэн, тиймээс vie, invite хоёрын үндсэн гарал нь адил юм. Dis-des-ээр эхэлж байсан хэдэн үгс одоо s-ээр эхэлдэг: stain бол distain-ий богиносгосон хэлбэр, эртний франц хэлэнд desteindre-ямар нэгэн зүйлийн будгийг гаргах гэсэн утгатай.

⁹ Үгийг богиносгон товчилж бичих нь цаас, цаг Henry Bradley, The making of English, 1964. x.151

үрэхгүй байх бөгөөд Англи хэлнээ ийм хэллэг цөөнгүй. Жишээ нь: ноён, хатагтай, үнэмлэх зэргийг товчлон үсгээр бичдэг. Бас British Broadcasting Corporation-BBC, overdose (хэт их тун)-OD, abbreviation-abbr гэх мэт. Ер нь товч үгийг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх нь зүйтэй. Монгол хэлний унадаг дугуй, дугуй хэмээх үгсийг өгүүлбэрт оруулвал: Би унадаг дугуй унаж байна. Би дугуй унаж байна. Эхний өгүүлбэрт уна-язгуур бүхий хоёр үг орж найруулга зүйн хувьд үг илүүдсэн, хоёр дахь нь харин аятайхан болжээ. Нөгөө талаас унадаг дугуй зардаг хүн "Би дугуй зардаг" гэвэл олон төрлийн дугуйнаас чухам ямар дугуйг хэлсэн нь ойлгомжгүй хоцрох учраас "Би унадаг дугуй зардаг" гэх нь зүйтэй.

3. Root-Creation-Язгуур бүтээхүй

Нээлт хийх арга хэрэгслийн дутагдлаас болж гарал нь тодорхойгүй олон үг англи хэлэнд бий. Энэ бол үнэн. Гэвч эртний англи хэлээс ч өвлөгдөөгүй, ямар нэгэн гадаад хэлээс ч зээлдээгүй найруулан холбох болон үүсмэл үг бүтээх процесс ч явагдаагүй мөн л олон үг бий. Уламжлалт болон гадаадаас зээлдсэн үгстэй харьцуулахад харьцангуй бага тоотой. Язгуур бүтээхүйн (эдгээр үгс бол язгуур үндэс, гаралгүй) гол төрөл нь onomatopoeia (цуурайдаган дуурайсан буюу давтагдсан үгс) юм. Үг нь грек, үгчилсэн утга нь нэрийг-бүтээхүй. Грекчүүд үүнийг дуу чимээ эсвэл биетээс гарч буй авиа зэрэг үзэгдлийг илэрхийлэхэд хэрэглэж байв. Заримдаа дуу авиаг нь дуурайж нэр өгдөг байв. Onomatopoeia өндөр ач холбогдолтой, гэвч үгсийн сангийн цар хүрээ нь үнэхээр бага.

'Цуурай'-'echoic' үгсийн тоо (английн хэлшинжлэлч, доктор Мюри ийнхүү нэрлэсэн) дундад болон орчин цагийн англи хэлэнд нэлээд олноор гарч иржээ. Заримыг дурдвал: cuckoo, thud-пад хийх чимээ, hush, bang, boo-бүү гэж орилох, boom-цуурайтах, уйлах дуу, cackle, cheer, fizz, gibber, giggle, hiss, hum, tumble, pop, quack, simmer, sizzle, whirr-чагчигнах чимээ, дүнгэхэн дуу ... ба давтагдсан үгс: bow-wow-нохойн хуцалт, чимээ шуугиан, ding-dong диндон гэх чимээ, хонхны дуу, flip-flop-санжигнан дуугарах, hee-haw, ping-pong, pom-pom, tick-tack, see-saw (дүүжин даажин, дээш доош хөдлөх) гэх мэт¹⁰.

Энэ нэрсийн эхний хэсэгт байгаа зарим үгсийг эртний англи хэлээс олж үзэх боломжтой бөгөөд энэ төрлийн үгс ярианд уран зохиолоос илүү өргөн хэрэглэгддэг. Манайд ч нэг хүүхдийн тоглоомыг 'дүүжин, даажин' гэж дууддаг нь нь магадгүй түүнээс гарч буй дуу, авианаас нь үүдсэн байх гэж бодогдож байна. Ийм маягаар үүсэн зарим монгол үгс гэвэл миний таамгаар: хуржигнах, сүр сархийх, хэрхэрэх, ёолох, майлах, мөөрөх гэх мэт. Мөн нялх хүүхэд голдуу анх ма, ба хэмээн анх хэлд орж, эцэг эхийгээ анх

дуудаж эхэлдэг. Тиймээс дэлхийн олон улс оронд ялангуяа эх хүн "м" үсгээр эхэлсэн үгтэй голдуу байдаг нь хүүхдийн анхны дуу авианаас үүдсэн байж болох талтай. Англид mom, mam, mother, оросод мама, солонгост ума, хятадад ма ма гэх мэт. Манайд зарим нутагт ээжийг амаа гэж авгайлж дуудах нь бий. Эцгийн нэр ч бас олон оронд төстэй дуудагддаг.

Давтаж дуурайсан үгс хэзээ ч утгаа яг таг илэрхийлж чаддаггүй. Ямар ч байсан ихэнх үед хөхөөний донгодолт хоёр гийгүүлэгчээс бүтсэн байдаг. Энэ шувуу олон зүйл, тэдгээрийн дуу авиа нь өөр өөр боловч хү хү, гү гү, кү кү гэж донгодох нь голдуу сонсогддог бөгөөд үүнээс уламжлан зарим орон дуугаар нь, дууны ард, урд нь сүүл, толгой хийж нэр өгсөн байдаг. Жишээ нь: англид cuckoo-күкүү, оросод кукушка, монголд хөхөө, солонгост бөгүги (), хятадад бүгү () гэх мэт. Мөн буу дуугарах, шалан дээр хүнд биет ойчиход англичуудад "бэн" гэж сонсогддоогоос "bang" нэр үг (пас хийсэн чимээ, гэнэтийн хүчтэй цохилт), "to bang" гэсэн үйл үг (балбах, чулуулах, мөргөх, пас хийх) үүсжээ. Урт эгшгээр хөдөлгөөний удааныг, нэг гийгүүлэгчийг давтах нь үйлийн давталтыг харуулж байдаг. Битүү үе, ялангуяа эгшгийн өмнө орсон p,t,k мэтийн дуугүй гийгүүлэгчид нь огцом болон ширүүн хөдөлгөөнийг илэрхийлж байдаг бол сонсоход хүнд, чихэнд хатуу сонсогддог гийгүүлэгчид бас ийм үгэнд тохирох нь мэдэгддэг.

Гэхдээ дуу авианууд хэл хэлнээсээ болж ялгардаг. Дээр гарсан хөхөөний донгодолтыг улс орнууд өөр өөрийнхөөрөө илэрхийлж буйгаас харахад илт. Энэ нь хэл бүрийн авианы тогтолцоо ондоо байдгаас болдог болов уу. Азарган тахиануудын орилооныг англичууд cockadoodledoo гэж ярьдаг бол оросууд kukurriku (орос ардын үлгэрүүдэд ийн бичсэн байдгийг санагтун), германд kikeriki, францад coquelico гэгцгээдэг. Мөн англид нохойн архирааныг. bow-wow, оросод гав гав, германд wau-wau, францад tou-tou, монголд хав хав, хятад, японд wan-wan гэж тэмдэглэдэг.

Заримдаа, авианы нийтлэг шинж нь түгээмэл ойлголттойгоо холбоотой байдалтай. Англи хэлэнд gl-p эхэлсэн glare, glint, gleam, glitter, glossy, glaze, glance, glimmer, glimpse, glisten эд бүгдээрээ гялбаа, агшин зуурын гэрэл гэсэн ойролцоо утгуудыг заадаг. Монгол хэлэнд мөн иймэрхүү үгс байдаг нь гялбаа, гялгар, гялалзах, гялтганах гэх мэт.

Тэмдэглэж хэлэхэд дундад болон орчин цагийн англи хэлэнд олон тооны язгуур бүтээхэд идэвхтэй хэрэглэгдэж байсан зүйл бол авиан тэмдэг, тэмдэглэгээ (phonetic symbolism) юм. Үүнд гийгүүлэгчийг өөрчлөлгүйгээр зөвхөн эгшгийг нь хувиргаж санаандгүй нээсэн үгс орно. Blob, bleb, blub-cheeked зэрэг үг нь утгын хувьд арай өөр боловч бүгдээрээ хөөсөн, бамбайсан

¹⁰ Henry Bradley, The making of English, 1964. x.55



зүйлийг илтгэдэг. Мөн jiggle-хи хи инээх, jogle-нүдээ бүлтийлгэн харах; flip-няслах, flap-сүр пархийх, flop-падхийтэл унах; chip, chap, chop, fible, famble, fumble, flash, flush гэх мэт.

Зориуд нээсэн язгуур-бүтээхүйн олон өвөрмөц, содон жишээг нийлмэл үгсийг шинэ үгсийн дундаас харж болно. Гэхдээ үүнийг хэлэнд байнга бий болгоно гэж төлөвлөдөггүй. Английн зохиолч Лэвис Карролл Alice in Wonderland (Алис, гайхамшигийн оронд), Through the Looking-glass (Нөлөөт толиор аялсан нь), The Hunting of the Snark зэрэг номууддаа шинэ, шинэ үг оруулсан байна. Тэднээс хоёр үг-galumphing (хүнд болхи алхаагаар хөдлөх) ба үйл үг to chortle (зохиолдоо дуулах, баярлан дуулах гэсэн утгаар орсон. Хожим нь утга нь өргөсөж инээх, дотроо инээхийг ийн хэлдэг болжээ) нь өдөр тутмын яриа, толь бичигт оржээ.

Ингээд англи хэлэнд хамгийн өргөн тархаж, хэвшсэн шинэ үг бүтээх гол гурван аргын талаар цухас дурдахад ийм байна. Үүнээс гадна нэг их онцгой биш боловч хааяа хэрэглэгддэг аргууд бас бий. Үүний нэг нь Blending буюу хоёр, түүнээс дээших үгийг нэгтгэж нэг үг болгох арга. Өөрөөр хэлбэл, үг найруулах өвөрмөц хэв шинж юм. Ингэж бүтсэн үгийг Portmanteau word гэх ба энэ латин гаралтай нэр томъёо 1579 онд анх үүсжээ. Энд breakfast-өглөөний зоог, lunch-үдийн зоог хэмээх хоёр хэллэгээс өглөө, үдийн зоогийн хооронд барьдаг бас нэг зоог гэсэн утга заадаг brunch, smoke-утаа, fog-манан-аас smog-утаа, манан гэсэн үг үүсжээ. Энэ аргыг дээр өгүүлсэн composition-буюу найруулан холбох аргын нэг дэд арга болгож авч үзэж болох юм. Монгол хэлэнд үүнтэй төстэй үгс (импорт+экспорт=импэкс) бий.

Бас Ex nihilo хэмээх ямар ч гарал, язгуургүй үгс байдаг. 1580 онд анх энэ латин нэр томъёо үүсжээ. Ийм үгэнд логик-учир шалтгаан байдаггүй. Жишээ нь: grok. Энэ үгийг Роберт Хейнлейн "Танихгүй нутгийн танихгүй этгээд" (Stranger in a Strange land) хэмээх романдаа анх оруулсан. Нэгэн математикчийн есөн настай хүүгийн 1938 онд бий болгосон googol гэх үг бас бий. Энэ нэр томъёог математикт хэрэглэдэг бөгөөд $1\text{googol}=10^{100}$ байна. Жишээ нь: 10^{googol} буюу $10^{10^{100}}$. Тоон тэмдэглэгээг үгээр илэрхийлсэн нь сонин л юм. Сүүлийн үед Ex nihilo-г onomatopoeia-аас гадна язгуур бүтээхүйн бас нэг гол арга хэмээн үзэж буй.

Үүнээс гадна балчир хүүхдийг сайн ажиглавал тэд заримдаа ямар нэгэн шалтгаангүйгээр шинэ үг бүтээдгийг анзаарна. Тэд тоглоом зэрэгтээ нэр өгч, нэг юм уу хоёр өдөр хэрэглээд дараа нь мартаж орхидог. Сонирхолтой нь зарим үгийг хамт тоглож байгаа хүүхдүүд, эцэг эх нь жинхэнэ үг гэж хүлээн авч, улмаар тэр үг ярианы хэлнээ тархах тохиолдол хааяа гардаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Henry, Bradley. (1964). *The making of English*. New York

Sheard, J. A. (1962). *The words we use*. London

Otto, Jespersen. (1962). *Growth and structure of the english language*. Great Britain

Sumiya, Ts. (1999). English

www.merriam-webster.com/help/faq/history.htm

www.anglik.net/englishlanguagehistory.html

<https://www.englishclub.com/english-language-history.htm>

<http://www.oxforddictionaries.com/words/the-history-of-english>

<http://www.studyenglishtoday.net/english-language-history.html>

<http://www.kryystal.com/english.html>